

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/1/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70593113

Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Дотоод хяналт.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	6
3.4 Материаллаг байдал.....	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	7
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	7
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	8
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
8. Аудитын илрүүлэлт.....	11
8.1 Залруулсан алдаа.....	11
8.2 Албан шаардлага.....	11
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ-УС ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ О.БАРХҮҮ ТАНАА**

2022.03.28 № 95

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын дарга санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020926

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,720,738.50	145,355,260.78
1.1.02	Дансны авлага	130,038,301.26	235,224,317.82
1.1.06	Бараа материал	5,729,216,819.97	8,473,354,942.56
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,878,975,859.73	8,853,934,521.16
1.2.01	Үндсэн хөрөнгө	34,868,793,795.33	34,003,685,326.21
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	34,868,793,795.33	34,003,685,326.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	40,747,769,655.06	42,857,619,847.37
2.1.1.01	Дансны өглөг	4,158,296.50	377,785.00
2.1.1.03	Татварын өр	20,979,942.67	3,063,982.55
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,138,239.17	3,441,767.55
2.1.2.01	Урт хугацаат зээл	7,498,905,983.41	10,267,809,706.01
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,498,905,983.41	10,267,809,706.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,524,044,222.58	10,271,251,473.56
2.3.02	- хувийн	22,622,932,563.92	22,675,573,908.92
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,449,157,774.34	15,449,157,774.34
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-3,835,415,924.32	-3,835,415,924.32
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,012,948,981.46	-1,702,947,385.13
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-689,998,403.67
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,012,948,981.46	-1,012,948,981.46
2.3.11	Эздийн өмчийн дүн	33,223,725,432.48	32,586,368,373.81
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	40,747,769,655.06	42,857,619,847.37

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	962,792,587.92	1,387,624,757.37
02	Борлуулалтын өртөг	1,853,441,869.67	2,028,531,816.75
03	Нийт ашиг(алдагдал)	-890,649,281.75	-640,907,059.38
08	Бусад орлого	0.00	123,273,450.97
08.1	Орлогын дүн	0.00	123,273,450.97
10	Ерөнхий ба удирдлагын зардал	122,298,315.69	172,364,795.26
12.1	Зардлын дүн	0.00	172,364,795.26
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,012,947,597.44	-689,998,403.67
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,012,947,597.44	-689,998,403.67
24	Орлогын нийт дүн	-1,012,947,597.44	-689,998,403.67

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	22,622,932,563.92	15,449,157,774.34	-	-	33,223,725,432.48
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12	22,622,932,563.92	15,449,157,774.34	-	-	33,223,725,432.48

сарын 31-ээр үлдэгдэл			3,835,415,924.32	1,012,948,981.46	
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-689,998,403.67	-689,998,403.67
Өмчид гарсан өөрчлөлт	52,641,345.00	0.00	0.00	0.00	52,641,345.00
2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	22,675,573,908.92	15,449,157,774.34	3,835,415,924.32	1,702,947,385.13	32,586,368,373.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,021,530,204.44	1,800,281,001.30
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,008,135,924.85	1,641,989,774.90
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,394,279.59	158,291,226.40
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,022,147,817.41	1,674,646,479.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	322,083,530.11	383,834,656.07
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	43,318,939.74	58,790,898.16
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	256,098,196.50	437,382,664.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	143,986,262.72	164,691,006.15
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	101,486,110.00	101,571,955.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	97,098,601.05	155,821,684.38
1.2.9	Бусад мөнгөн зарлага	58,076,177.29	372,553,614.53
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-617,612.97	125,634,522.28
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-617,612.97	125,634,522.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,338,351.47	19,720,738.50
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,720,738.50	145,355,260.78

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2021 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого	985,493,600.00	1,510,898,200.00	525,404,600.00	153.3
2	ББӨ	2,520,606,300.00	2,028,531,800.00	(492,074,500.00)	80.5
3	Нийт ашиг	(1,535,112,700.00)	(517,633,600.00)	1,017,479,100.00	33.7
4	Ерөнхий удирдлагын зардал	201,597,780.00	172,364,800.00	(29,232,980.00)	85.5
5	Цалингийн сан	653,760,100.00	422,240,510.00	(231,519,590.00)	64.6

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Т.Оюун-Эрдэнэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт, санхүүгийн хяналт, шалгалтыг Санхүүгийн хяналт, аудитын албанаас гүйцэтгэдэг, тайлант онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,200,896.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 22,009.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын зорилго нь "Зардал бууруулж эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөн ажлын чанар хүртээмжийг сайжруулахад"-д оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвийн ард иргэдийг цэвэр ус олборлон хангах, бохир ус татан зайлуулах, дулаан хангамж, халуун усны үйлчилгээгээр хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 1942 оны 79 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4-т */орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих/* гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг аймгийн Засаг дарга, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын дарга томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн тухай хууль 78 дугаар зүйлийн 78.2-т */орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох/* заалттай нийцэж байна.

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин олгодоггүй, 2021 онд гишүүн бүрд нэг удаа 1,800.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.12-т */Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно/* дахь заалт, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 2-ны өдөр баталсан “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.15-т */Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин урамшуулал олгож болно/* гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ

г.м)-ын зардлыг гаргахгүй байх,”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ТУЗ-өөс баталсан зардлыг 521,307.5 мянган төгрөгөөр хэмнэн 2,200,896.6 мянган төгрөгийн зардлыг тайлагнасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,720.7	145,355.3	125,634.5
БХХО			-
Авлага	130,038.3	235,224.3	105,186.0
Урьдчилгаа			-
Бараа материал	5,729,216.8	8,473,354.9	2,744,138.1
Үндсэн хөрөнгө	34,868,793.8	34,003,685.3	(865,108.5)
Биет бус хөрөнгө			-
Нийт хөрөнгийн дүн	40,747,769.7	42,857,619.8	2,109,850.2
Өр төлбөрийн дүн			-
Богино хугацаат өглөг	25,138.2	3,441.8	(21,696.5)
Урт хугацаат өглөг	7,498,906.0	10,267,809.7	2,768,903.7
Эздийн өмч	33,223,725.4	32,586,368.4	(637,357.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	40,747,769.7	42,857,619.8	2,109,850.2

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 145,355.3 мянган төгрөг болж өмнөх оноос 125,634.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үүнээс ХААН банкны 4 дансанд 143,646.6 мянган төгрөг, Төрийн банкны 1 дансанд 538.5 мянган төгрөг, Хас банкны 1 дансанд 1,132.6 мянган төгрөг, нийт 145,317.7 мянган төгрөгийг арилжааны банканд байршуулсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 235,224.3 мянган төгрөг болж, 105,186.0 мянган төгрөгөөр өссөн нь Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай 209, 211 дүгээр тогтоолуудыг гарган, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцсантай холбоотой Засгийн газраас 180,654.56 мянган төгрөгийн авлагыг нэмж тайлагнасан нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 205,404.9 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 29,810.3 мянган төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд найдваргүй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,473,354.9 мянган төгрөг болж 2,744,138.1 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр 2020 оноос аймгийн цэвэрлэх байгууламжийг барьж эхэлсэнтэй холбоотой дуусаагүй барилгыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд худалдан авалтаар 406,041.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 2,768,903.7 мянган төгрөг, нийт 3,174,942.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгө актлаагүй, шилжүүлж хасаагүй байна.

Биет бус хөрөнгө 30,622.0 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн программ, орон сууцны программыг тус тус бүртгэснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3,441.8 мянган төгрөг болж өмнөх оноос 21,696.5 мянган төгрөгөөр буурсан бол урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 10,267,809.7 мянган төгрөг болж өмнөх оноос 2,768,903.7 мянган төгрөгөөр өссөн байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хийгдээгүй, Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр баригдаж байгаа цэвэрлэх байгууламжийн 2021 оны санхүүжилттэй холбоотой өссөн байна.

Шалгагдагч байгууллага Азийн хөгжлийн банкнаас 2009 онд 2,191,702.0 мянган төгрөгийн зээлийг олгойн говийн цэвэр усны шугамыг шинээр тавих зориулалттай авч, зээлийг зориулалтын дагуу буюу цэвэр усны шугам, түүнийг бэлтгэхэд зориулж техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна. Азийн хөгжлийн банкнаас авсан зээл төлөгдөхгүй байгаа нь төлбөрийн чадамжгүйтэй холбоотой, ханшийн өсөлтөөс шалтгаалан төлбөл зохих зээлийн дүн өсөх үр дагавартай байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий удирдлагын зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 230,664.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь албан хаагчдын цалинг нэмсэн, цэвэрлэх байгууламжтай холбоотой орон тоо нэмэгдсэн, бараа, үйлчилгээний үнэ өссөнөөс шалтгаалжээ.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цэвэр, бохир ус, халуун ус, дулаан үйлдвэрлэлийн зардлуудыг хамруулсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт хуваарилагдахгүй зардлууд байхгүй байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 985,493.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,090,791.3 мянган төгрөгөөр, 1,105,297.7 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Шинэчлэн байгуулагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 21-ний 2 дугаар тогтоолоор нийт орлогыг 985,493.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,722,204.1 мянган төгрөгөөр, алдагдлыг 1,736,710.5 мянган төгрөг байхаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 1,510,898.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,200,896.6 мянган төгрөгийн зардал гарган, 689,998.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогыг 525,404.6 мянган төгрөг буюу 53.3 хувиар давуулсан нь Засгийн газраас коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай 209, 211 дүгээр тогтоолуудыг батлан, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцсантай холбоотой айл, өрхүүдийн болон эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанаас шалтгаалан цэвэр усны хэрэглээ өссөн, мөн бусад орлогууд өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 521,307.5 мянган төгрөг буюу 19.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 47 нэр төрлийн үндсэн хөрөнгийг 296,664.9 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Тайлант онд цэвэр алдагдал 689,998.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,046,712.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь төлөвлөсөн урсгал завсрын ажлууд дутуу хийгдсэнтэй холбоотой байна.

Түрээсийн төлбөрийн 30 хувь болох 5,116.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь-Ус ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 1,466,580.7 мянган төгрөгийн 165 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 681,712.0 мянган төгрөгийн 78 мэдээллийг дутуу мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Шалгагдагч байгууллага нь албан шаардлагын хэрэгжилтийг заасан хугацаанд албан бичгээр ирүүлжээ.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	0	1	0			100
Зөвлөмж							
Нийт дүн	1	0	1	0			100

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого, шатахууны давтан тооцооллыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 191,850.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 172,384.8 төгрөгийн алдааг залруулж, 19,465.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 172,384.8 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 172,364.8 мянган төгрөгийн удирдлагын зардлыг хасах утгатайгаар тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн зарлагыг 20.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

8.2 Албан шаардлага

- Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэн, 681,712.0 мянган төгрөгийн 78 гүйлгээг дутуу мэдээлсэн;
- Санхүүгийн тайлан дахь 19,465.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудал																
1	Дундговь-Ус ОНӨААТҮГ	ДУА-2022/1/НА-СТА-ОНА	Санхүүгийн тайлан дахь авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	Харилцагч байгууллагуудтай авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд тусгаж байх	1	19,465.4					1	19,465.4				
2			Орлогын дэлгэрэнгүй тайланд удирдлагын зардлыг хасах утгатайгаар тайлагнасан		1	172,364.8	1	172,364.8								
3			Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн зарлагыг илүү тайлагнасан		1	20.0	1	20.0								
ДҮН					3	191,850.2	2	172,384.8			1	19,465.4				
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
4	Дундговь-Ус ОНӨААТҮГ	ДУА-2022/1/НА-СТА-ОНА	Шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлэн, 681,712.0 мянган төгрөгийн 78 гүйлгээг дутуу мэдээлсэн	Шилэн дансны тухай хууль, цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах							1	0				
ДҮН											1	0				
НИЙТ ДҮН					4	191,850.2	2	172,384.8			2	19,465.4				

